



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 11 сарын 13-аар

Дугаар А/498


Мандалговь

Г Төсөл санхүүжүүлэх тухай Т

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, 58 дугаар зүйлийн 58.2.1, 58.2.17 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 8.1.2 дахь заалт аймгийн ИТХ-ын 2017 оны 25 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын Зөвлөлийн 2018 оны 11 дүгээр сарын 02-ны 15 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 12 сарын 4-ны өдрийн 25 дүгээр тогтоолоор батлагдсан "Хөтөлбөр арга хэмжээ"-ний зардлаас "Залуу багш нарын зөвлөгөөн" төслийг дэмжиж, "Боловсролын үнэлгээний хөгжлийн төв" ТББ (Р.Энхбат)-аар гүйцэтгүүлсүгэй.

Хоёр. "Залуу багш нарын зөвлөгөөн" төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах 1,190,000 (нэг сая нэг зуун ерэн мянга) төгрөгийг аймгийн 2018 оны ОНХС-ийн "Хөтөлбөр арга хэмжээ"-ний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (А.Ганбат)-т, гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир)-т, Нийгмийн бодлогийн хэлтэс (А.Нарантуяа)-т тус тус даалгасугай.



438010535